Бараа материалын эцсийн үлдэгдлийн 31.7 хувийг дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл байгаа бөгөөд тус дансанд оны эхэнд Соёл амралтын хүрээлэнгийн тохижилтын ажил, Цэцэн ОЗ дугаар багийн төвийн барилга бүртгэлтэй байснаас тайлант онд Цэцэн ОЗ дугаар багийн төвийн барилга бүрэн хийгдэж ашиглалтад орж хасагдсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн сумын сургуулийн спорт заалны барилгын дээврийн засварын ажлын санхүүжилтийг аймгийн ОНХС-аас бүрэн аваагүй, ажил хийгдэж дуусаагүй тул нөөцийн барааны оны эцсийн үлдэгдэл 50,000.0 мянган төгрөг байгаа нь бараа материалын эцсийн үлдэгдлийн 15.8 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	41,433.9	163,874.7	122,440.7	61.3
2	ИТХ	421.0	2,806.0	2,385.0	1.0
3	ОНХС	235,671.5	100,570.4	(135,101.1)	37.6
	<b>Дүн</b>	<b>277,526.4</b>	<b>267,251.1</b>	<b>(10,275.3)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 257,231.0 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 23,998.0 мянган төгрөгийн бараа материал бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжиж авч, үйл ажиллагаанд 241,504.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

**3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,054,997.0 мянга, эцсийн үлдэгдэл 3,129,111.0 мянган төгрөг болж, 74,114.0 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	2,260,684.4	1,959,643.8	(301,040.6)	62.63
Тээврийн хэрэгсэл	201,514.2	285,194.2	83,680.0	9.11
Машин тоног төхөөрөмж	147,838.8	159,991.1	12,152.2	5.11
Тавилга эд хогшил	42,382.5	50,997.7	8,615.1	1.63
Номын фонд	1,761.3	1,761.3	-	0.06
Бусад үндсэн хөрөнгө	364,908.7	635,615.9	270,707.2	20.31
Программ хангамж	475.0	475.0	-	0.02
Бусад биет бус хөрөнгө	35,432.0	35,432.0	-	1.13
<b>Дүн</b>	<b>3,054,997.0</b>	<b>3,129,111.0</b>	<b>74,114.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 21,252.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 982,928.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагаас шилжүүлэн авсан бөгөөд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нэг барилга акталсан, холбогдох

газрын шийдвэрээр бүртгэлд тусгасан сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг акталсан байна.

**Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	2,903,902.9	2,109,271.4	(794,631.5)	94.9%
2	ИТХ	151,094.1	112,649.4	(38,444.7)	5.1%
	<b>ДҮН</b>	<b>3,054,997.0</b>	<b>2,221,920.8</b>	<b>(833,076.2)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.4.5 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,115.0 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүйгээс байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэл өөрчлөлтгүй байна.

**Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Ажиллагсадтай холбоотой	Үүнээс:	
					Байгууллагад төлөх өглөг	Бараа үйлчилгээний зардлын өглөг
1	ЗДТГ	3,115.0	3,115.0	0.0	3,115.00	0.0
	<b>ДҮН</b>	<b>3,115.0</b>	<b>3,115.0</b>	<b>0.0</b>	<b>3,115.0</b>	<b>0.0</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх өглөг нь 2022 онд үүссэн аймгийн Сум дундын Ойн ангид төлөх өвсний үнийн өглөг бөгөөд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн холбогдох хүнээс 2024 оны 05 дугаар сард багтаан төлүүлэхээр шийдвэрлэсэн боловч өглөг барагдаагүй байна.

**3.4.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,670,294.2 мянга, эцсийн үлдэгдэл 3,359,709.3 мянган төгрөг болж, 689,415.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	511,503.9	511,503.9	-	15.2
Хуримтлагдсан үр дүн	1,879,168.8	2,714,043.5	834,874.7	80.8
Өмнөх үеийн үр дүн	1,879,168.8	2,024,628.4	145,459.6	
Тайлант үеийн үр дүн		689,415.1	689,415.1	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	279,621.5	134,161.9	(145,459.6)	4.0
<b>Дүн</b>	<b>2,670,294.2</b>	<b>3,359,709.3</b>	<b>689,415.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх үеийн үр дүн дансны үлдэгдэл өмнөх оноос 145,415.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, мөн дүнгээр хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс буурсан нь сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

**3.4.7 Орлогын данс**

Баянцагаан сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12/07 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 400,136.9 мянга, татварын бус торгуулийн орлогыг 7,000.0 мянган, нийт 407,136.9 мянган төгрөгөөр баталсныг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор цалин хөлс, түүнтэй адилтгах

орлогыг 16,710.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр татварын орлогыг 416,846.9 мянган төгрөгөөр баталжээ.

*Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/*

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>249,310.0</b>	<b>291,608.3</b>	<b>(42,298.3)</b>	<b>117.0</b>
1. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	183,810.0	209,201.9	(25,391.9)	113.8
2. Үйл ажиллагааны орлого	8,000.0	11,601.5	(3,601.5)	145.0
3. ҮХЭХ борлуулсны орлого	4,000.0	14,276.0	(10,276.0)	356.9
4. Хадгаламжийн хүү	53,500.0	56,528.9	(3,028.9)	105.7
<b>Өмчийн татвар</b>	<b>8,460.0</b>	<b>6,271.3</b>	<b>2,188.7</b>	<b>74.1</b>
1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,100.0	1,501.3	598.7	71.5
2. Бууны албан татвар	6,360.0	4,770.0	1,590.0	75.0
<b>Бусад татвар, төлбөр хураамж</b>	<b>159,076.9</b>	<b>204,629.4</b>	<b>(45,552.5)</b>	<b>128.6</b>
1. Улсын тэмдэгтийн хураамж	13,000.0	27,650.4	(14,650.4)	212.7
2. Газрын төлбөр	2,000.0	1,751.7	248.3	87.6
3. Түгээмэл тархацтай АМНАТ	500.0	300.0	200.0	60.0
4. Малын тоо толгойн албан татвар	65,352.9	43,996.1	21,356.8	67.3
5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10,000.0	7,553.5	2,446.5	75.5
6. Ус рашаан ашигласны төлбөр	13,000.0	16,987.5	(3,987.5)	130.7
7. Ан амьтны нөөц ашигласны төлбөр	52,224.0	106,390.1	(54,166.1)	203.7
8. Газрын дуудлага худалдааны орлого	3,000.0	-	3,000.0	-
<b>Татварын бус орлого</b>	<b>7,000.0</b>	<b>6,563.2</b>	<b>436.8</b>	<b>93.8</b>
1. Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	818.2	181.8	81.8
2. Торгуулийн орлого	6,000.0	5,745.0	255.0	95.8
<b>Орлогын нийт дүн</b>	<b>423,846.9</b>	<b>509,072.2</b>	<b>(85,225.3)</b>	<b>120.1</b>

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 120.1 хувь буюу 85,225.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь дараах орлогууд давж биелсэнтэй холбоотой байна. Үүнд:

- Тайлант онд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 117.0 хувиар биелсэн;
- Боловсролын байгууллагын жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр амжилттай үнэлэгдсэн багш нарт урамшуулал олгосон нь үйл ажиллагааны орлого давах шалтгаан болсон;
- Баянхонгор аймгийн ИТХ-аас гарсан шийдвэрийн дагуу хуучин ашиглаж байсан сэргээгдэх эрчим хүчний 100 ширхэг нарны толийг тус бүрийг 100.0 мянган төгрөгөөр борлуулж орон нутагт төвлөрүүлэх шийдвэр гарсны дагуу худалдан борлуулж 10,000.0 мянган төгрөгийг татварын орлогод төвлөрүүлсэн;
- Засгийн газрын 2017 оны 339 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн БОАЖГ-ын дарга, аж ахуйн нэгжүүдтэй 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан “Агнуурын амьтан агнах” гэрээний дагуу тайлант онд 2 угалз, 4 тэх агнасан агнуурын орлогоос 26,642.4 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж, 106,390.1 мянган төгрөгийн ан агнуурын орлого орон нутагт төвлөрсөн байна.

Харин иргэд үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, буу, газрын төлбөр, малын тоо толгойн албан татвар төлөх үүргээ бүрэн биелүүлээгүйгээс тус орлогууд тасарсан байгаа байна. Өмнөх аудитаар татварын орлогыг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг сумын ИТХ батлахдаа сумын ЗДТГ өөрийн орлогоор 1,000.0 мянга, Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн

орлогоор 60,704.3 мянган төгрөг оруулахаас гүйцэтгэлээр сумын ЗДТГ орлогыг биелүүлээгүй байна.

Хүснэгт 12. Өөрийн орлого /мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Өөрийн орлогын эх үүсвэрийн талаар тайлбар
1	Баянцагаан	ЗДТГ	1,000.0	811.4	(188.6)	81%	Нохойны татвар, тендерийн баримт бичгийн үнэ, албан бланкын үнэ
2	Баянцагаан	Сум хөгжүүлэх сан	60,704.3	68,792.1	8,087.8	113%	Зээлийн хүү, эргэн төлөлт
		<b>ДҮН</b>	<b>61,704.3</b>	<b>69,603.4</b>	<b>7,899.1</b>		

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,269,000.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,898,955.1 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 846,617.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 292,157.8 мянган төгрөгийг тогтмол зардалд, 760,180.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баянцагаан сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж хүргүүлсэн аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12/07 дугаар тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 2,045,780.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор анх 2,045,780.1 мянган төгрөгөөр баталсан, анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, урьд оны үлдэгдлийг 90,321.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилтийг 24,536.4 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 91,653.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн анхны төсвөөс нийт дүнгээр 223,220.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийг 2,269,009.9 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 13. Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	Анхны баталсан 2022.12.19 өдрийн 12/07 тогтоол	Сумын ИТХ-ын 2023.07.07-ны өдрийн 15/03 тогтоол	Дүнд эзлэх хувь
1	татварын орлого	400,136.9	416,846.9	18.4
2	Татварын бус орлого /торгуулийн орлого/	6,000.0	6,000.0	0.3
3	Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	453,103.1	544,756.5	24.0
4	Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	537,226.1	561,762.5	24.8
5	өөрийн орлого ЗДТГ	1,000.0	1,000.0	0.0
6	Өөрийн орлого Хоршоо хөгжүүлэх сан	60,704.3	60,704.3	2.7
7	Сумын төсвийн урьд оны үлдэгдэл	375,678.8	419,378.8	18.5
8	Сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл	161,930.9	208,551.9	9.2
9	Сумын хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл	50,000.0	50,000.0	2.2
ДҮН		2,045,780.1	2,269,000.9	100.0

*Эх сурвалж. Баянцагаан сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12/07, 2023 оны 15/03 дугаар тогтоол*

Баянцагаан сумын ИТХ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийг үндэслэн хандив, тусламжийн орлогоор 100,000.0 мянган төгрөгийг оруулан, орон нутгийн санд зарцуулахаар төлөвлөсөн атлаа орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна.

*Хүснэгт 14. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОНТ-г төвлөрүүлсэн
1	ЗДТГ	435,943.3	402,911.5	33,031.8	96.4	35,189.8
2	ИТХ	75,304.7	74,307.6	997.1	97.5	997.1
3	ЕБС	148,571.3	140,106.4	8,464.9	66.2	8,464.9
4	Цэцэрлэг	47,867.8	41,166.8	6,701.0	64.6	6,701.0
5	ЭМТ	24,494.4	23,189.6	1,304.8	94.7	1,304.8
6	Соёлын төв	22,299.7	18,466.0	3,833.7	91.4	3,833.7
7	ОНХС	708,206.8	257,928.3	450,278.5	34.8	
8	Хоршоо хөгжүүлэх сан	152,862.3	90,100.0	62,762.3	141.0	-
9	Орон нутгийн сан	100,000.0	-	100,000.0	0.0	
ДҮН		1,715,550.3	1,048,176.3	667,374.0	61.0	56,491.2

*Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,048,176.3 мянган төгрөг буюу 61.1 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 56,491.2 мянган төгрөгөөр хэмнэсэн, ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг 450,278.5 мянган төгрөгөөр дутуу хэрэгжүүлсэн, Сум хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүйгээс 62,762.3 мянга, хандив, тусламжийн орлогоор оруулахаар төлөвлөсөн 100,000.0 мянган төгрөг оруулаагүй зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баянцагаан сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 110,285.6 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,300.0 мянга, нийт 111,585.6 мянган төгрөгийн санхүүжилт орсноос бараа үйлчилгээний бусад зардалд 7,837.6 мянган төгрөгийг зарцуулан, ЗДТГ хэмнэлтийн 103,315.8 мянга, ИТХ 432.2 мянга, нийт 103,748.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд сумын Засаг даргын харьяаны байгууллагууд тавьсан зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 15. Хүрэх үр дүнгийн биелэлт /мянган төгрөгөөр/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2023 оны зорилтот түвшин	2023 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	
1	2	3	4	5	6	7	
<b>БАЯНЦАГААН СУМ</b>					<b>2,269,000.9</b>	<b>1,898,955.1</b>	
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	Сумын ИТХ-ын үйл ажиллагаа	Хурлын хуралдааныг улиралд доошгүй, 1-с удаа хуралдуулж шийдвэр гаргана.	Орон нутгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөгөөг батлан гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.	116,095.7	93,399.1
2	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, ард иргэдэд төрийн бодлого шийдвэрийг хүргэх, Засаг захиргааны анхан шатны нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмж үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого төлөвлөлтийг зохион байгуулах	Хууль тогтоомжийн хүрээнд төрийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлж түүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайлагнасан.	854,537.6	716,671.8
3	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчигээг хэвийн явуулах	Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн	77,302.3	75,645.8
4	71702	Соёл урлаг	Соёл урлаг	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчигээг хэвийн явуулах	Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн	40,504.2	35,240.2

5	71801	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсрол	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчигээг хэвийн явуулах	Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн	26,026.5	24,451.0
6	71802	Ерөнхий боловсрол	Ерөнхий боловсрол	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчигээг хэвийн явуулах	Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн	144,163.0	129,161.9
6	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	Хоршоо хөгжүүлэх сан	Хоршоо хөгжүүлэх сангаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох, бодлогоор дэмжих	Сумын жижиг дунд үйлдвэрлэл, хоршоодын хөгжлийг дэмжих зорилгоор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийг олгож ажлын байр бий болгох	110,704.3	64,205.0
	70503	орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	Орон нутгийн хөгжлийн сан, Их засварын арга хэмжээ	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хууль тогтоомжинд нийцүүлэн төлөвлөх, бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтыг нэмэгдүүлэх	Хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай ашиглах, хууль тогтоомж, журам зааврын хүрээнд төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.	899,667.3	760,180.3

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын харьяа байгууллагуудын биелэлт, санхүүгийн тайлан

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, үе шатны хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

Баянцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга Н.Гансүх, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга Д.Аюуш нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Их" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны баталсан төсөв 2,269,000.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 34,035.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 23,824.5 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Баянцагаан сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар дараах зардлуудыг хэмнэсэн байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь байгаль орчны байцаагч, хөдөө аж ахуйн тасгийн 2 мэргэжилтэн орон тоо дутуу ажилласан тул цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, урамшууллын зардал хэмнэгдсэн;
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 16. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,176.3	411,596.3	40,580.0	91.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,521.0	50,726.4	5,794.6	89.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,000.0	5,901.0	3,099.0	65.6

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянцагаан сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 89 мэдээлэл оруулахаас 87 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Баянцагаан сумын ОНХС 228,684.6 мянган төгрөгийн мэдээлэл, сумын ЗДТГ нь 35,552.2 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл дутуу байршуулсан, орхигдуулсан зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баянцагаан сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудитор Н.Батчимэг, ИТХ болон тусгай сангуудын санхүүгийн тайланд аудитор Д.Цэдэвцэвээн нар завсрын аудитыг 2023 оны 12 дугаар сард гүйцэтгэж, дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

*Хүснэгт 17. Завсрын аудитаар илэрсэн зөрчлийн тоо, дүн /мянган төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчлийн тоо	Мөнгөн дүн
1	ЗДТГ	1	-
2	ИТХ	1	200.0
3	Хоршоо хөгжүүлэх сан	1	1,940.3
4	Орон нутгийн сан	1	44,596.9
	ДҮН	4	46,737.1

*Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тайлан*

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар илэрсэн дээрх зөрчлийг төсөвт байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд залруулж арга хэмжээг авч ажилласан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Баянцагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл аудит хийж, малын тоо толгойн албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг өгч, хууль журмын хэрэгжилттэй холбоотой 1, дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал 1, төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 1 асуудалд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ нь "Хязгаарлалттай" санал дүгнэлт авч, ИТХ болон 2 тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдаж, сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Баянцагаан сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 45,110.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Хүснэгт 18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Материаллаг эсэх	Зөрчлийн ангилал
А	1	2	3	4	5	6
1	Баянцагаан сумын ОНХС	Аймгийн Засаг даргын 2023.08.07-ны өдрийн А/424 тоот захирамжаар "Сургуулийн спорт заалны барилгын дээврийн засварын ажлыг" сумын ОНХС-д эрх шилжүүлж санхүүжилт 100,000.0 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас шилжүүлэхээр шийдвэрлэсэн ба аймгийн ОНХС-аас 50,000.0 мянган төгрөгийг шилжүүлж үлдэгдэл санхүүжилтийг өгөөгүй байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, гэрээний үнийн дүн болох 89,193.7 мянган төгрөгийг бүрэн шилжүүлсэн байна.	44,596.9	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
2	Баянцагаан сумын ИТХ	ИТХ-ын танхимын өрөөний тохижилт хийхээр урсгал засварын зардлаас "Болор ТБББЛ" ХХК-аас 2023.09.30-нд зиг заг хавтан 10 ширхэг нэр бүрийг нь 200.0 мянган төгрөгөөр худалдан авахаар төлбөрийг бүрэн төлсөн боловч материал ирээгүй байхад дансанд үлдэгдлээр бүртгэсэн байна.	200.0	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
3	Баянцагаан сумын ЗДТГ	Үйлдвэрчний эвлэлээс авах авлагыг 229.8 мянган төгрөгөөр илүү, ХХОАТ-ын авлагыг 83,8 мянган төгрөгөөр дутуу тусгасан.	313.6	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
ДҮН			45,110.5			

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл

Баянцагаан сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 349,790.3 мянган төгрөгийн 8 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,400.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 302,279.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага ажилласан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Материаллаг эсэх	Зөрчлийн ангилал
A	1	2	3	4	5	6
1	Баянцагаан сумын ОНХС	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлэхдээ нийт 152,684.6 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын нийт 76,000.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	228,684.6	Албан шаардлага өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
ДҮН			273,281.5			
1	Баянцагаан сумын хоршоо хөгжүүлэх сан	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан 12 зээлдэгчийн 16,841.3 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна.	16,841.30	Албан шаардлага өгсөн	Материаллаг	Санхүүгийн аудит
ДҮН			16,841.30			
1	Баянцагаан сумын ИТХ	Баянцагаан сумын ЗДТГ, ИТХ-ын албан тушаалтнууд Улаанбаатар хотод зохион байгуулсан Төрийн албаны зөвлөлийн манлайллын сургалтад хамрагдсан зардалд 1,901.7 мянган төгрөгийн зардлыг сумын ИТХ-аас тушаал, шийдвэргүй олгосон байна.	1,901.7	Албан шаардлага өгсөн	Материаллаг	Санхүүгийн аудит
2	Баянцагаан сумын ИТХ	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын тушаалаар ИТХ-ын төлөөлөгч нарт 2023 оны 21, 23 дугаар захирамжаар нийт 1,400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна	1,400.0	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
ДҮН			3,501.70	-	-	-
1	Баянцагаан сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс багийн эмч нарт нэг бүр нь 3,050.0 мянган төгрөгийн үнэ бүхий 6,100.0 мянган төгрөгийн 2 мотоцикл, цэцэрлэгт 3,000.0 мянган төгрөгийн ширээ, сандал авсан.	9,100.0	Албан шаардлага өгсөн	Материаллаг	Санхүүгийн аудит
2	Баянцагаан сумын ЗДТГ	Тайлант хугацаанд Ланд 470 авто машинд 8,800.0 мянган төгрөгийн мотор, 1,400.0 мянган дугуй авч сольж тавьсан бөгөөд сэлбэг хэрэгслийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.	10,200.0	Албан шаардлага өгсөн	Материаллаг	Санхүүгийн аудит
3	Баянцагаан сумын ЗДТГ	Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 42 тушаал, захирамж байршуулахаас 24 тушаал, захирамжийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32,552.2 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.	35,552.2	Албан шаардлага өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
4	Баянцагаан сумын ЗДТГ	Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаар захирамжаар дуучин М.Түмэнсайханы цомгийн зардалд засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн	1,000.0	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
ДҮН			56,165.9			
<b>НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН</b>			<b>349,790.3</b>			

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл

## Аудитын илрүүлэлт

Аудитаар орон нутгийн төсвийг бүрдүүлж байгаа татварын орлогыг бүрэн биелүүлээгүй зөрчил илэрсэнд албан шаардлагыг хүргүүлэв.

### 5.1. АЛБАН ШААРДЛАГА

1. Баянцагаан сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгийн татвар, бууны татвар, газрын төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татвар, малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй, Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө”, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд сумын төсөвт төвлөрөх албан татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Баянцагаан сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгийн татвар, бууны татвар, газрын төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татвар, малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй, Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	0	0	0	1	0	0	0
Дүн	1	0	0	0	1	0	0	0

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 249/АОСБ0232/БНА  
2024/16/НА - СТА-ТМЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянцагаан сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгийн татвар, бууны татвар, газрын төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын албан татвар, малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй, Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх "Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө", Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно", 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар

5040756

D/2024-ASH

тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын дарга Н.Гансүх, санхүүгийн албаны дарга Д.Аюуш нарт даалгав<sup>2,3</sup>.


**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно